

М.Гантуяа

Шашин судлалын
тэнхимийн багш, Ph.D

ОРЧИН ҮЕИЙН ШАШНЫ СЭТГЭЛ ЗҮЙН ФИЛОСОФИЙН ҮНДЭСЛЭГЭЭ

Товч утга: Орчин үеийн шашин судлалд шашны сэтгэлзүйн асуудал чухал байр эзэлдэг. Шашны сэтгэлзүйн ямар ч хандлага, арга зүй байлаа гэсэн түүнд санаа өгсөн философийн уг үндэслэгээ заавал олддог юм. Иймээс орчин үеийн өрнийн шашны сэтгэлзүйд санаа өгсөн гол гол философийн үндэслэгээнүүд, тухайлбал орчин үеийн сэтгэл судлалд нэлээд гол байр эзэлж байгаа бихевиоризм болон гештальт психологи, психоанализын аргад үзэл санааны түлхэц өгсөн философийн иррационал, позитив, прагматик үзэл баримтлалуудын талаар энд тойм төдий боловч авч үзье.

Түлхүүр үг: religion, psychology, irrationalism, existentialism, positivism, pragmatism, behaviorism, gestalt psychology, personalism.

Шашин судлал дахь шашны түүх-онол, шашны философи, шашны социологи гэх мэт олон салбарууд дотроос шашны сэтгэлзүйн үүрэг ач холбогдол улам бүр өссөөр байна. Шашин хэрэгтэй юу, хэрэггүй юу, бурхан чөтгөр байдаг уу, байдаггүй юу, аль шашин илүү, аль шашин дутуу, аль нь үнэн, аль нь худал, хэн илүү сүсэглэж, хэн дутуу сүсэглэж байна зэрэг шашин сүсэг бишрэлийг тойрсон олон янз асуудал дотроос хүний сэтгэл санаанд нэгэнт үүссэн сүсэг бишрэл хувь хүний оюун санааны ертөнцөд ямар байр суурь эзэлдэг, амьдрал, үйл ажиллагаанд нь ямар үүрэг гүйцэтгэдэг вэ гэсэн асуудалд шашны сэтгэлзүй гол анхаарлаа хандуулж байна. Энд сүсэгтний шүтээн бурхан нь ямар бурхан байна гэсэн асуудал гол биш, харин сүсэгтний сэтгэлзүйн байдал ямар байна вэ гэсэн асуудал чухал болдог.

Яагаад сүсэгтэн хүн “миний дэргэд бурхан байна, тэр надтай ярьж байна, тэр надад тусалж байна” хэмээн бүрэн итгэж, тэрхүү итгэлээрээ амьдарч, ажиллаж байдаг юм бэ? Яагаад “чиний бурхан бол хуурамч бурхан” гэсэн үгэнд автагдалгүй итгэл үнэмшилдээ үнэнч байдаг юм бэ? Тийм сүсэгтнүүдтэй бид хэрхэн «тэмцэх» вэ, бидний тэмцэл тэдэнд ямар нөлөө үзүүлэх вэ, нийгэмд хэрэгтэй, улс эх орны уламжлал хөгжилд таарч тохирох тийм шашинд сүсэгтнүүдийг хэрхэн итгүүлэх вэ гэсэн асуудалд шашны сэтгэлзүй өөрийн хариултаа өгөх учиртай. Сүсэг бишрэл гэдэг бол хүний сэтгэлийн нэн гүн нандин зүйл байдаг. Хүний хайр сэтгэлийн асуудал хэр эмзэг байдаг билээ, сүсэг бишрэл гэдэг бол сэтгэл санааны ертөнц дэх тэр чинээний эмзэг үзэгдэл мөн.

“Хүн сүсэг бишрэлийг амсан мэдрэх байдал нь сэтгэл судлаачийн хувьд хүний ухамсрын аливаа бусад үзэгдлээс

дутахааргүй анхаарлыг нь татдаг. Сэтгэлзүйн хүрээнд байх тохиолдолд бид шашны номлол, зан үйлийг биш, харин сүсэг бишрэлийн мэдрэмж, сэтгэл санааны байдлыг авч үзнэ” (3, 14). Иймээс шашны сэтгэлзүй нь бүх хүмүүст хүртээлтэй түгээмэл үзэгдлээс илүү хувь хүмүүст учирдаг онцгой тохиолдлуудыг судалдгаараа шашин судлалын бусад салбаруудаас ялгардаг юм. Шашин, сүсэг бишрэлийн сэтгэлзүйн орчин ба түүний философийн утга учир гэдэг бол ялгаатай хоёр өөр асуудал болно.

Орчин үеийн сэтгэл судлалд нийгмийн орчин, нийгмийн амьдралын судалгаанаас илүү хувь хүний сэтгэлийн ертөнц рүү орж, тэрхүү ертөнцийн нууцыг тайлахад гол анхаарлаа хандуулдаг бихевиорист болон гештальт арга зүйн хандлагууд бий болсон байна. Бихевиорист арга зүйн үүднээс бол шашны сэтгэлзүй нь хүний сэтгэлийн далд нууц орчин руу орж түүнийг ойлгож ухаарахад чиглэнэ, өөрөөр хэлбэл хувь хүний нууц бодол санааг уншина гэсэн үг юм. Бихевиористууд хүний сэтгэл зүйн байдалд хяналт тавьж, түүний цаашдын төлөвийг урьдчилан тогтоохыг оролддог байна. Хүний төрөлхийн сэтгэл хөдлөлийн төлөв нь байнгын давтамжит гадаад орчны нөлөөгөөр үүсдэг гэдэгт үндэслэн хүний сэтгэл санааны ертөнцөд гаднаас нэвтрэн орж түүнийг удирдаж болно гэж үздэг. Ямар ч хүний зан төлөв, сүсэг бишрэлийг үндсээр нь өөрчилж болно гэсэн үг. Харин гештальт психологийн арга зүйгээр бол сэтгэлзүйн аливаа тусгаар үзэгдэл нь хувь хүний сэтгэлзүйн бүхэл нэгдмэл дүр төрхийнх нь нэг хэсэг болно. Иймээс сүсэг бишрэлийн сэтгэлзүйн судалгаагүйгээр хувь хүний сэтгэлзүйн ерөнхий дүр төрхийг тогтоох боломжгүй юм. Гэхдээ сүсэг бишрэл дангаараа сэтгэлзүйг бүхэлд нь илэрхийлэхгүй. Сэтгэлзүйг илэрхийлэх бусад бүх элементүүдтэй салшгүй нягт уялдаа холбоонд л ерөнхий сэтгэлзүйн дүр төрөх нь гардаг.

Орчин үеийн шашны сэтгэлзүйн ямар ч хандлага, арга зүй байлаа гэсэн түүнд санаа өгсөн философийн үндэслэгээ заавал олддог юм. Өөрөөр хэлбэл философи нь психологид шинэ санааг өгч байдаг салбар болой. Иймээс орчин үеийн шашны сэтгэлзүйд санаа өгсөн гол гол философийн үндэслэгээнүүдийн талаар тойм төдий боловч авч үзье.

Шашин, сүсэг бишрэлийг авч үзэж байсан нийгэм, танин мэдэхүйн онолоос ангид, түүнийг цэвэр сэтгэлзүйн хүрээнд оруулах оролдлогыг иррационал хандлага гэнэ. Энд хатуу логик сэтгэлгээний эсрэг айн эмээх, сэтгэл хөдлөх, догдлох зэрэг психологийн үзэгдлүүдийг гол болгон авсан байна. Иррационалистууд оюун ухааны оронд хүний сэтгэлийн дотоод хөдөлгөөнийг чухалчлан, нийгэм-түүх, хүний амьдрал соёлын гол шалгуур нь сэтгэл хөдлөл хэмээн үзжээ.

Иррационализмыг үндэслэгч Кьеркегор хувь хүний, тухайлбал өөрийн амьдрал хувь заяаг философийн үндсэн асуудал болгосон юм. Хүний оршихуй буюу экзистенцийн асуудал нь цэвэр хувь

шинжтэй, тиймээс ч нэн олон шийдэлтэй болой. Кьеркегор хүний сэтгэлийн ертөнцийг биеэ даасан, тусгаар ертөнц болох хувьд нь авч үзжээ. Байгалийг судалдаг шинжлэх ухааны аргаар хүний сэтгэлийг судалж болохгүй, хүн гэдэг бол онцгой оршихуй учраас онцгой аргаар, гаднаас нь биш, харин дотроос нь л судална гэж үзсэн байна. Эндээс л хүнийг шинжлэх ухаанаас ангид аргаар, шинжлэх ухааны рационал аргаас тэс ондоо иррационал аргаар судлах асуудлыг дэвшүүлсэн ажээ.

Хөрөнгөтний нийгэм нь оюун ухаан, сэтгэлгээг өндөрт өргөн гарч ирсэн боловч түүний хөгжлийн үр дүнд хувь хүний сэтгэл зүй, хувь заяаны зөрчилт байдал нэн тодоор илрэх болсон билээ. Кьеркегор бүх хүн төрөлхтний өмнө тавигддаг асуудлыг дэвшүүлээд өөрийнхөө хувийн амьдралын туршлагаараа шийдвэрлэсэн байдаг. Ёс суртахууны хатуу дэглэм, сэтгэлийн бясалгал, сүсэг мөргөл бол түүний эрхэмлэгч зорилго байв. Тэрээр амьдралд “шийдвэртэй”, “сонголттой” байхыг чухалчлан үзсэн юм. Нийгмийн амьдралын гол утга учир нь захирагдан дуулгавартай байх явдал гэж үзжээ. Улс төрийн хүрээнд ч, шашны хүрээнд ч дуулгаваргүй, захирагдах дургүй байдлаас л бүх зовлон зөрчил үүснэ. Ямар нэг зүйлд эргэлзэн, үл итгэснээс дуулгаваргүй байдал үүсдэг. Хүн өөрийнхөө үнэн гэсэн үзэл санааг олж түүнийхээ төлөө амьдарч үхэх ёстой хэмээн Кьеркегор үзжээ.

Түүний үзлээр шашин хүмүүст туйлын итгэл сүсэг, дуулгавартай байдлыг төрүүлнэ. Шашны номлол утгагүй хийсвэр байх тусмаа сүсэг бишрэлийг ихээр төрүүлнэ. Утгагүй хийсвэр зүйлд л хүн итгэдэг, сүсэглэдэг. Санваартнууд бурхан шашинд хэт итгэж чаддаггүй, жирийн хүний амьдралын хойноос хөөцөлдөх нь элбэг байдаг учраас л сүсэг бишрэлийг гутаадаг юм. Сүсэг бишрэл гэдэг бол оюун ухаанаас тэс эсрэг зүйл мөн. Оюун ухаан л шашин, сүсэг бишрэлийн дайсан. Хүн бүр амьдралыг хөнгөвчлөхөд хэрэг болох ямар нэг юм бүтээх гэж үйл ажил эрхэлж байдаг. Гэтэл амьдрал хүнд хүчир байх тусмаа утга учиртай болдог юм биш биз хэмээн Кьеркегор бясалгажээ. Рационалистууд ерөнхий хүрээнд дүүлээд л байхаас нэгж хувь шинжтэй зүйл дээр бууж ирж чаддаггүй юм. Тэд нэгж хувь шинжийг ерөнхий зүйл болгон хувиргана. Гегелийн хувьд ерөнхий хоол л байхаас өөрийн дуртай хоол ч гэж байхгүй. Тэр оршихуй гэж юу вэ гэдгийг ойлгохгүй. Миний оршихуй нь миний сэтгэлгээ, миний оюун бодомжинд байдаг зүйл биш, харин амьдрал, мэдрэмж, сэтгэл хөдлөлд байдаг зүйл юм гэдэг. Ингэж Кьеркегор рационал танин мэдэхүй, ухааран сэтгэхүйн оронд сэтгэл хөдлөлийг тавьсан байна. Би өөрийн оршихуйтайгаа оюун ухаан дахь түүний тусгалаар дамжуулж танилцахгүй, харин амьдралын урсгал дунд танилцана. Хүмүүст ерөнхий яриа хэрэггүй, харин түүний хувийн амьдралд хэрэг болох тодорхой зүйл л хэрэгтэй байдаг. Хүн өөрөө өөрийнхөө амьдрал хувь заяаг сонгож, өөрийгөө аврах хэрэгтэй болдог. Хүний амьдралын утга учир нь өөрийгөө аврахад л оршино.

Хүн авралын замаа өөрөө сонгодог ба энэхүү сонголт нь хүний оршихуйн цөм болдог. Чөлөөт сонголт ба түүнийхээ төлөө хүлээх хариуцлага нь хүний эрх чөлөөт оршихуйн мөн чанар болно. Хүний мөн чанар бол эрх чөлөө хэмээн Кьеркегор номлосон буй.

Түүний үзлээр хүн өөрийгөө аврахын тулд гоо зүйн, ёс зүйн, шашны гэсэн гурван шатыг туулдаг. *Гоо зүйн* шатанд хүн гадаад ертөнц рүү хандаж, мэдрэхүйн хүрээнд амьдардаг. *Гоо зүйн* түвшинд байснаар хүн гадаад ертөнцөөс хамааралтай болдог. Гадаад ертөнц хаашаа байна, хүн тийшээ урсгал даган хөвнө. Иймээс хүн *ёс зүйн* түвшин рүү өөрийн эрхгүй шилжинэ. Энэ үед сэтгэл ханамжийн хойноос хөөцөлдөхөө больж, үүргээ ухамсарлах байдал давамгайлна. Мэдрэхүйн чөлөөт тоглоомоос сайн дураараа татгалзаж ёс зүйн жам хуулинд захирагдаж эхлэнэ. Ёс суртахуунтай байхын тулд ёс зүйн хууль зарчмыг мэдэхээс гадна өөртөө тохирсныг сонгож мөрдөх чадвартай байх хэрэгтэй. Сонголт гэдэг бол хэний ч өмнө хариуцлага хүлээх албагүй итгэл үнэмшил мөн. Эцсийн дээд *шашны* шатан дээр хүн түгээмэл хуулинд захирагдах хэрэггүй болж, хувийн дотоод бурхантайгаа буюу дээд үнэмлэхүй байдалтайгаа холбогдоно. Хүн юуг зөв гэж сонгоно, тэр л зөв зам мөн. Итгэл үнэмшил, сүсэг бишрэл гэдэг бол үнэний шалгуур болно. Хүн өөрийн өмнө тулгарсан хүнд бэрх асуудлыг өөрийн итгэл үнэмшлээр л шийдэх нь зөв. Хэрвээ ямар нэг юмнаас шалтгаалж асуудлыг шийдэж байвал тэр эрх чөлөөгүй хүн болно. Оюун ухаан, бодрол бясалгалаас хамааралгүй зүрх сэтгэлээ л сонсох хэрэгтэй. Хүн өдөр тутмын асуудлуудыг амьдралын урсгалаар шийддэг боловч хүнд бэрх тулгамдсан чухал асуудлыг шийдвэрлэх агшинд өөрийн оршихуйгаа эс оршихуйн эсрэг утгаар мэдэрдэг юм. Бурхан харагдахгүй, батлагдахгүй. Туйлын сонголт тулах агшинд л хүн туйлын эрх чөлөөгөө гүйцэлдүүлдэг. Энэ бол ертөнцийн ямар нэг юм үзэгдлийг өөрчлөн хувиргах эрх чөлөө биш, харин мөнхийн диваажинг олох эрх чөлөө юм. Хүн аз туршсан эрс үсрэлт хийж чадвал өөрийн жинхэнэ Би-гээ олж авна. Өөрийн нь бурхан өөрийн нь нүглийг наминчилж өөрийнхөө эрх чөлөөг мэдрэх болно гэх мэтээр Кьеркегор сүсэг бишрэлийг сэтгэлзүйн үүднээс тайлбарлажээ.

Бүхний амьд, бүтээгч эхлэл нь хүний танин мэдэхүйн чадвар бус, харин ухамсаргүй сохор дур хүсэл л амьдралд хүч өгдөг гэж Кьеркегорын шавь Шопенгауэр үзсэн байдаг Оюун ухаан бол хүний төрөлх мөн чанар биш, тэр нь ухаангүй дур хүслээс урган гардаг. Ийнхүү Шопенгауэрын үзлээр сэтгэлгээ, оюун ухаан, "рацио"-г амьдрал, амьдралын хүч, дур хүслийн хүчирхийлэл хоёрдогч байранд түлхэн гаргасан юм.

Германы нэрт философич Ницше христос шашинт европын нийгмийн ёс зүйн номлол болон "европын хүмүүсийн" тогтсон атгаг үзэл баримтлалыг халж, цоо шинэ эрхэмлэгч зорилгыг (идеалыг) шинээр тогтоохыг хүсчээ. Ницшегийн философийн бодролууд нь

ямагт сэтгэл зүйн хөдөлгөөнт хувь шинжтэй боловч объектив үндэслэлтэй, нийгмийн агуулгатай байдаг.

Ницшегийн үзлээр, амьдралын үнэ цэнэ нь урт удаан хугацаандаа биш, харин агшин зуурын мэхлэлт байдаг оршино. Ертөнцийн өөр нэг чухал шинж нь захирах дур хүсэл – эсрэг тэсрэг хүчнүүдийн идэвхтэй харилцан үйлчлэл юм. Харилцан үйлчлэл гэдэг бол захирах дур хүслийн илрэл. Ахуйн ч, танин мэдэхүйн ч, гоо сайхны ч, шашны ч, ёс суртхууны ч суурь шинж нь захирах дур хүсэл болой. Зорилго чиглэлтэй хөдөлгөөн, зохион байгуулалт, дэс дараалал, арга хэрэгсэл зэрэг нь захирах дур хүслийн үр дагавар юм.

Танин мэдэхүй гэдэг бол тайлбарлахуй мөн гэж Ницше үзсэн байна. Баримт гэж байхгүй, тайлбар л гэж байна. Тайлбарлалаас ангид үйл явдал гэж байхгүй. Ертөнцийг танин мэддэг биш, харин тайлбарладаг юм. Иймээс үй түмэн тайлбар байж болно.

Ницшегийн үзлээр бол, хуулийг нь биш, хууль зохиогчийн сэтгэл зүйг судлах нь нэн тэргүүний зүйл болно. Хязгааргүй олон тайлбар байж болох боловч үнэн тайлбар хэзээ ч олдохгүй. Амьдрал заавал үнэн байх албагүй. Худал тайлбар, төөрөгдөл ч амьдрал мөн. Бид зөн совин дотроо, зөн совингоороо амьдардаг. Тайлбарлалын олон утга нэг утган дээр хэзээ ч очихгүй.

Хүн ерөөс бусдаас дээгүүр гарах гэж, хувь заяанаасаа илүү ихийг шаардаж байдаг. Ингэснээрээ өөрөө өөрийнхөө боол болно хэмээн Ницше үздэг.

Тэрээр Европт дэлгэрсэн сократын, иудейн, христосын гэсэн гурван ёс суртахууныг шүүмжилсэн байдаг. Эдгээр нь хүчтэй чөлөөтэй хүмүүсийн эсрэг сүрэглэн амьдрагсдын зөн совин, аз жаргалтай хүмүүсийн эсрэг зовон тарчлагч буруутнуудын зөн совин, онцгой хүмүүсийн эсрэг дундчуудын зөн совин мөн боловч ядуучуудыг тогтоох нөхцлүүдийн нийлбэр юм. Хүчтэйчүүд хүч султнуудын амьдралын горимыг хүлээж авах юм бол өөрсдөө сүрэглэн амьдрагч болж хувирна. Иймээс чөлөөт сэтгэгчид ёс суртахууны өмнө буруугүй байдаг. Буруугүй байдал гэдэг бол агуу зориг, агуу эрх чөлөө. Христос шашин европчуудаас энэ чанарыг нь алдагдуулсан юм. Тэрээр хүнийг бурханы өмнө буруутан болгодог. Сүргээр амьдрагсдын зөн совин нь хэзээ нэгэн цагт өөрсдийнх нь гарт орж ирэх хүмүүсийг бий болгодог учраас тэдний шашин, ёс суртхууныг ёс суртахуунгүй шашингүйчүүд дэмждэг юм. Захирагч хүмүүст шашныг устгах хэрэг байхгүй, харин чөлөөт сэтгэлгээ, буруугүй байдал, өөрийн гэсэн зорилго, өөрийн гэсэн арга хэрэгсэл хэрэгтэй. Үүний тулд үнэ цэнэ гэж юм байдаг. Тэр нь үйл ажиллагаа явуулах үндэс болно. Үнэ цэнийг үнэлэх чадвар бол бүтээгч, чөлөөт хүний шинж болой гэх мэтээр Ницше шашны ёс суртахууны сэтгэл зүйн үндсийг тайлбарлажээ.

"Анхдугаар хэлэлцүүлэг дэх үнэн бол христос шашны үнэн болой: христос шашин нь ressentiment-ийн оюун ухаанаас төрсөн

болохоос ихэнх хүмүүсийн боддогчлон "оюун ухаанаас" төрсөн бус, үнэн чанартаа энэ нь буцах хөдөлгөөн, язгууртны үнэ цэнэ ноёрхохын эсрэг аугаа бослого байв. Хоёрдугаар хэлэлцүүлэг нь хүнлэг нандин чанар бүхий сэтгэл зүйг өргөн барина: тэр бол ихэнх хүмүүсийн боддогчлон "хүний доторхи Бурханы дуу хоолой", тэр бол дахин цэнэглэгдэж чадахаа больсон, хойшоо, дотогшоогоо харсан, хатуу харгис чанартай зөн совин болой. Гуравдугаар хэлэлцүүлэг дэх даяанчлан эрхэмлэгч зорилго, хуврагийн эрхэмлэгч зорилго нь хэдийгээр *par excellence*-д хортой эрхэмлэгч зорилго, үхэлд тэмүүлсэн дур зорго, *decadence*-ийн эрхэмлэгч зорилго байдаг ч тэр нь хаанаас гарч аймшигтайгаар ноёрхон захирч байна вэ гэсэн асуултад хариу өгнө. Хариу нь: Хүмүүсийн гол төлөв боддогчлон тэрээр бурхан хуврагийн араар тавьдаг учраас бус, харин *faute de mieux* - өрсөлдөгчгүйгээс өнөөг хүртэл цорын ганц эрхэмлэгч зорилго болдог... Эдгээр нь бүхий л үнэ цэнийг дүгнэх сэтгэл судлаачийн гурван шийдвэрлэгч бэлтгэл ажил болно. Энэ ном нь хуврагийн анхны сэтгэл судлалыг идэрхийлнэ" хэмээн Ницше бичжээ (5, 451-452.)

Ницшегийн үзлээр шашинлаг чанар бол хүмүүсийн зэвүүцмээр дүр төрхөөс залхсан эрхэм дээд хүний тухай буруу ойлголт юм. Хүмүүсийн дунд амьдрагч эрхэм дээд хүнийг хүмүүс ойлгохгүй. Өөрсдөөсөө илүү эрхэм дээд хүнийг бий болгоход бидний утга учир оршино. Бурхан мөхөж болно, харин эрхэм дээд хүн амьдрах ёстой. Хуучинсаг үзлийг уудлан илрүүлж, төөрөгдлийг арилгаж, өөрөө өөртөө чин сэтгэлээрээ байх явдал бол эрхэм дээд хүн төрөх нөхцөл болно. Үнэнд тэмүүлэх биш, харин өөрөө өөртөө сэтгэлээсээ хандах явдал бол эрхэм дээд хүний хамгийн гол чанар мөн. Сократад ч, христос шашинд ч энэ чанар байгаагүй. Гэхдээ чин сэтгэлээрээ байна гээд ариун хувраг болж болохгүй. Бусдад сэтгэлээсээ биш байдлыг заан сургаж, бусдад чин сэтгэлээсээ биш хандаж болох боловч өөрөө өөртөө чин сэтгэлээрээ л байх хэрэгтэй хэмээн Ницше үзжээ.

Нэг хүний хувьд шудрага зүйл нөгөө хүний хувьд шудрага биш байж болно. Бүх нийтээр тогтоосон ёс суртахууныг шаардах нь дээд хүний хувьд хор болно. Хүн бүр өөрийн гэсэн философитай байдаг. Ёс суртахуун бол бөөрөнхий. Түүний эсрэг тал байдаг бөгөөд тэр нь оршин байх эрхтэй гэж Ницше номложээ.

Түүний үзлээр түүх бол хууль зүй тогтолт үйл явц биш, харин хүн юу болж, юу хийж чадахыг үзүүлэх үлгэр жишээнүүдийн цуглуулга юм. Иймээс жинхэнэ түүх гэж байхгүй. Ертөнцийг христос шашны ёс суртахууны үүднээс тайлбарлах болсон үеэс хүн төрөлхтнийг тэгшитгэн, олон түмэн ноёрхох үйл явц эхэлсэн юм. Христосын шашин-ёс суртахууны хэлбэрээр гарч ирсэн хүч султнуудын бослогыг тэтгэсэн Ромын эзэн хаад засгийн эрхийг хэтрүүлэн ашиглах болсон санамсаргүй үйл явдал нь улмаар Европт хүч султнуудын ялалтыг байгуулж, ардчиллын үе эхэлсэн ба энэ үйл

явцад төгсгөл байхгүй. Нийгмийн ардчилсан байгууллагууд бол доод хүний ноёрхлын хэлбэр юм. Дээд ариун төрлийн тухай бодохгүй байхад л ард түмэн гэсэн ойлголт бий болно. Ардчилал нь хүнийг үйрүүлэн жижигрүүлж, хүмүүсийг тэгшитгэн, зөвхөн "дэвших" чиглэлээр хөгжинө. Бүх хүн маш адилхан, маш жижиг, маш бөөрөнхий, маш нийцтэй, маш уйтгартай болно. Тэд дээд хүнийг сулхан хуулбарлаж, дээд хүний эсрэг тэмцэж, дээд хүний зэвсэг болж байдаг. Төрийг ардчилснаар тэр нь бүтээлч бие хүмүүсийг дарлах олон түмний зэвсэг болсон юм. Энэ тохиолдолд төр хаана дуусна, тэнд хүн эхэлнэ гэдэг.

Психоанализыг үндэслэгч Фрейд нийгмийн амьдрал, соёлын амьдралыг сөнөөгч нь тэрхүү нийгмийн гишүүн нь байдаг, хувь хүн байдаг гэж үзжээ. Иймээс соёл нь ямагт хувь хүмүүст зориулсан хоригуудыг боловсруулан гаргадаг. Бурхад нь соёлын хамтын амьдрал дахь хоригуудыг хэрхэн биелүүлж байгаагаар нь хүмүүсийг шүүн тунгаана. Аль нэг бурхныг бүх дэлхийд ноёрхуулах хүсэл нь тухайн бурхны хоригоор бүх хүмүүсийг шүүнэ, өөрөөр хэлбэл тухайн соёлыг дэлхийд ноёрхуулна гэсэн үг юм. Хүмүүс уламжлалыг дагаад, нийгмийн харилцаан дахь тайван байдлыг эрхэмлээд шашинд итгэдэг. Гэвч шашны дотор "аймшигтай олон тооны хүн аз жаргалгүй байж, түүнийг авч хаявал зохих дөнгө гэж үздэг ба ийм хүмүүс соёлыг өөрчлөхийн тулд бүх хүчээ зориулж байдаг... Тэд үргэлж шашны номлолыг цэвэр гадаад зүйл болгон, улмаар зорилгыг нь тэсэлж чаддаг байлаа" (6, 509-510). Ийнхүү Фрейдын үзлээр, хүний хүүхдэрхүү зан төлөв нь соёл руу хандах дургүй байдаг юм. Иймээс шашин бол бүх хүн төрөлхтний албадлагын сэтгэлзүйн гажуудал буюу невроз гэж хэлж болно.

Орчин үеийн социологийн шинжлэх ухааны эхийг тавьсан гэгддэг Дильтей юуны өмнө хүнийг тойрон хүрээлж байгаа гадаад орчны асуудлыг авч үзжээ. Сэтгэл санааны дотоод гүн байдлыг физик үйл явцаас ангид судалж болно. Үүнийг оюун санааны тухай шинжлэх ухаан гэнэ. Хүний оюун санаа нь тусгай зорилго бүхий физик үйлдлээр байгальд нөлөөлөх хүчин чадалтай. Оюун санааны тухай шинжлэх ухаан гэдэг нь үнэндээ биеэ даасан судлах зүйлтэй, өөрийн гэсэн судалгааны арга зүйтэй түүхийн буюу хүмүүнлэгийн ухаан юм. Байгалийн үзэгдлийг учир шалтгааны үүднээс тайлбарлах нь бидний сэтгэлгээнээс гарсан тайлбарлал юм. Харин оюун санааны тухай шинжлэх ухаан нь өөр агуулгатай, бидэнд өөр аргаар өгөгддөг билээ. Түүний судлах зүйл бол амьдрал. Амьдралыг ертөнцөөс биш өөрөөс нь гаргаж, харин ертөнцийг амьдралаас гаргаж тайлбарлана.

Дильтейн үзлээр хүний амьдрал гэдэг бол оюун санааны буюу ухамсрын амьдрал юм. Ухамсар нь хувь хүний сэтгэлзүйн амьдралын цогц болой. Энэхүү хувь хүний сэтгэлийн цогц амьдрал нь нийгмийн амьдрал болон түүнийг ойлгохуйн дүр төрх, эх сурвалж болдог. Нийгмийн амьдралын бүх үйл явц оюун санааны агуулгатай

учраас хувь хүний оюун санааны амьдралаас урган гарна. Оюун санааны амьдрал нь гаднаас өгөгддөг, бидний гадна байдаг зүйл биш. Иймээс түүнийг ойлгохын тулд дундаж завсрын холбоо хэрэггүй, бид түүнийг оюун санааны холбоо байдлаар шууд мэдэрдэг, бид түүгээр амьдардаг. Энэхүү шууд, зөн совингоороо ухаарах сэтгэлийн үзэгдлийг "ойлгохуй" гэнэ. Бид байгалийг тайлбарладаг, харин оюун санааны амьдралыг ойлгодог. Бидний амьдралдаа мэдэрч байгаа зүйлээс ямар ч логик гаргалгаа гаргаж болохгүй. Амьдралыг оюун ухааны шүүхээр оруулж болохгүй гэдэг. Дильтей сэтгэл судлалын нэгдсэн арга зүйгээр оюун санааны бүхий л түүхийг судлах, зохих шинжлэх ухаануудын системийн хүрээнд оюун санааны түүхэн ертөнцийг байгуулах зорилт тавьсан байна. Нийгмийн амьдрал гэдэг бол оюун санааны амьдрал, гэхдээ оюун санаа гэдэг нь сэтгэлгээ биш, харин хүсэл зорго, сэтгэл хөдлөлийн хүчин зүйлүүд юм. Иймээс бүх шинжлэх ухааны дотоод агуулга нь логик биш, харин сэтгэл судлал болно. Төр эрх, шашин судлал, урлаг судлал г.м. оюун санааг судалдаг ямар ч шинжлэх ухаан өөрийн судлах зүйлээ ойлгохын тулд сэтгэл судлал руу хандана. Иймээс сэтгэл судлал бол оюун санааг судалдаг шинжлэх ухааны арга зүйн үндэс нь болно. Дильтей уламжлалт туршилтын тойм сэтгэл судлалын оронд тайлбарлагч сэтгэл судлалыг тавьсан юм. Тойм сэтгэл судлал нь учир шалтгааны холбоогоор сэтгэлийн үзэгдлүүдийн хууль зүй тогтлыг гаргахыг оролддог. Тайлбарлагч сэтгэл судлал нь хүний мэдэрч байгаа тэрхүү сэтгэлийн төлөв байдлыг тайлбарлахыг зорьдог. Хүний сэтгэлийн нэгдмэл холбоо нь сэтгэгдэхгүй, харин мэдрэгдэнэ. Нийгэм, түүхийн амьдралын ямар ч үйл явцыг энэхүү тайлбарлагч сэтгэл судлалын аргаар авч үзэх ёстой. Тэдгээр үйл явц нь ухамсар, хүсэл зорго, сэтгэл хөдлөлийн хэлбэрээр явагдана. Шинжлэх ухаанч чанарын эрхэмлэгч зорилго нь мэдрэмжийг дахин мэдэрч түүнийг бүрэн ойлгох явдал билээ. Судалж буй түүхэн үйл явдал, үзэгдлийнхээ дотоодод нэвтэрч, мэдэрч чадвал шинжлэх ухааны өгч чадах зүйл болно. Энд зөвхөн сэтгэлгээ төдийгүй сэтгэлийн ертөнцийн бүхий л амьдрал хамаарна. Танин мэдэхээсээ өмнө ойлгох хэрэгтэй. Объект ба субъектын хооронд харилцан ойлголцох харилцаа үүсэх ёстой. Би өөрийгөө мэдэрч буй мэт судалж буй зүйлээ мэдрэх хэрэгтэй болно.

Феноменологи арга зүйгээрээ нэрд гарсан философич Гуссерлийн үзлээр бол, философи нь тайлбарлагч сэтгэл судлал мөн. Логик нь психо-феноменологи үндэслэгээтэй байна. Сэтгэл судлал нь тайлбарлагч шинжлэх ухаан бөгөөд нэгэнт оршин байгаа сэтгэлгээний урлагийг энгийнээр тайлбарладаг болохоос сэтгэлгээний уг мөн чанарыг ойлгодоггүй. Феноменологийн редукцээр эх үндэслэгээ рүү нэвтрэх шинжлэх ухаан-онолын илт тодорхой байдлыг гарган авах боломжтой болно. Шинэ мэдлэгийг үндсээс гаргаж авах гэдэг нь тодорхойгүй, харанхуй байдлын дэвшил юм. Үнэнийг гаргаж авах аргыг ойлгомжтой болгохыг

феноменологи тайлбарлал гэнэ. Үүний тулд практик сэтгэлгээний эмпирик техник ажиллагаа хэрэггүй, харин сэтгэлгээний техникийн жинхэнэ үндэс рүү нэвтрэх хэрэгтэй болно. Практик сэтгэлгээний үндэс нь танин мэдэхүйн психологи байдаг. Шинжлэх ухаан-онолын сэтгэлгээний үндэс нь цэвэр логик болой. Цэвэр логикийн хуулиуд нь априори шинжтэй байна, практик сэтгэлгээний хуулиуд нь дадал зуршил байдаг. Иймээс сэтгэлгээний суурь хууль нь байгалийн хууль биш, учир шалтгааны хууль биш болой. Онолын мэдлэгт бодит психологийн ба логик-ноэтикийн дээд байдал гэсэн хоёр нөхцөл шаардагдана. Логик судалгаа гэдэг бол субъектив ухамсрын судалгаа мөн. Аливаа илэрхийлэл нь тэмдэглэгээтэй байна. Тэмдэглэгээн дотроос хэл яриа хамгийн чухал нь байдаг. Үг хэл нь тэмдэглэхээс гадна илэрхийлдэг. Илэрхийлэл нь сэтгэл зүйтэй холбоотой. Сэтгэл зүй гэдэг бол ухамсрын агуулгын тал мөн. Харин тэмдэглэгээ нь утга холбогдолгүй (интенцгүй) илрэл болой. Юмсаас авсан сэтгэгдэл нь юмсын шинж чанартай адил байдаггүй. Дотоод сэтгэгдэл бол юмсын шинж чанарын гадаад тэмдэг болно. Ийнхүү тэмдгээс ойлголт руу, ойлголтоос бодрол руу, эсвэл объектын тухай сэтгэгдэл рүү хандсан хөдөлгөөн явагдана.

Экзистенциалист философийн том төлөөлөгч болох Ж.-П.Сартр үзэхдээ: миний болон бусдын эрх чөлөө адилгүй төдийгүй, миний амьдралын агшин тохирол бүрийн эрх чөлөө ч өөр хоорондоо адилгүй. Нэг эрх чөлөөг нөгөөгөөр солино гэдэг нь эхний эрх чөлөө алдагдана гэсэн үг. Нэг агшин тохиролд бүрэлдсэн эрх чөлөө өөр тохиролд алдагдана. Эрх чөлөөгүй хүн бол хүн мөн боловч экзистенциал утгаар үйл ажиллагаа явуулагч хүн биш юм. Эрх чөлөөт ахуй нь энгийн ахуйн эсрэг тал мөн. Хүн эсвэл эрх чөлөөтэй, эсвэл эрх чөлөөгүй байна. Эрх чөлөө хагас байна, хагас байхгүй гэж болохгүй. Мөн эсвэл сэтгэл зүйн хувьд, эсвэл танин мэдэхүйн хувьд эрх чөлөөтэй байна гэж болохгүй. Эрх чөлөө нь бүхэл цогц шинжтэй. Эрх чөлөөтэй байна гэдэг нь хүсч байгаа юмаа хүсэх, өөрөө өөрөөсөө үүсэн гарах явдал юм. Эрх чөлөө гэдэг бол амжилт биш. Эрх чөлөө гэдэг бол бие даасан сонголт мөн. Бид зөвхөн өөрийнхөө хувийн сонголт хийж байвал бие хүн болно. Бид бол сонголт хийдэг эрх чөлөө, гэхдээ бид эрх чөлөөт ахуйг сонгодоггүй, ахуй нь биднийг эрх чөлөө рүү хаясан юм. Эрх чөлөө гэдэг бол сугалаа шиг тохиолдлын сонголт биш. Өөртөө-зориулсан сонголт гэдэг бол ахуйн тасралт, шийдвэр гаргах агшин юм. Эрх чөлөөт хүний амьдрал гэдэг бол өөрөө өөрийгөө сонгосон сонголт, сонголт хийх агшинд ахуй тасрана. Хүн ямагт эрх чөлөөт хүн бөгөөд чөлөөт сонголтынхоо үрээр газар сайгүй саад тотгортой учирна. Сонголт гэдэг бол үргэлж сөргөлдөнө гэсэн үг. Эрх чөлөө нь хариуцлагаас ангид зүйл биш. Хүн ертөнцийг болон өөрийгөө хариуцдаг. Энэ бол түүний оршин ахуйн арга юм. Миний юм бүхэн надаар хийгдэнэ. Дайнд гэмгүй ялагдал гэж байхгүй. Би ертөнцөд хаягдсан эхний агшнаасаа л өөрийгөө хариуцна, би эрх чөлөөтэй бөгөөд хариуцлагатай. Ийнхүү Сартр эрх

чөлөөний асуудлыг шашингүйн экзистенциализмын үүднээс авч үзсэн юм.

Германы нэрт сэтгэл судлаач-философич Ясперс: "Хүн гэгээрээгүй буюу ариун бус байдлаас ангижирсан хутагтны ертөнцөд тааралдах дүрд орсон чинад байдалтай бодьтой холбогдох нь шашинд ямагт хамааралтай байдаг. Хаана ийм юм байхгүй, эсвэл үүнээс татгалзана, тэнд шашаны онцлог чанар алга болно. Түүхэн дурсамжинд өртөх хүн төрөлхтний бараг бүх амьдрал шашинлаг байдаг, энэ бол устгагдашгүй шашинд байх үнэний ба мөн чанарынх нь заалт юм" (9, 50) хэмээсэн буй. Чөлөөт сонголт хийсэн тохиолдолд л чинад дээд оршихуйтай холбогдоно. Гэвч экзистенц нь эргэлзээтэй байдаг учраас хүндрэлтэй тулгардаг юм. Экзистенц нь өдөр тутмын амьдралаар сэтгэл ханадаггүй. Хүн уналтынхаа, эсвэл нисэлтийнхээ мэдрэмжийн агшинд л чинад дээд оршихуйг хамт мэдэрч, амьдралаас уйдах сэтгэл төрнө. Чөлөөт ухамсар нь хүнийг байгалиас ч, бурхнаас салган өөрийн бие даасан байдлыг нь хангана. Өөрөө өөртөө таалагдахгүй байгаа байдлынхаа эсрэг тэмцэж, өөрийгөө ухамсарлаж, өөрийгөө танин мэдэж, амьдралыг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх, амьдрах чадвар нь эрх чөлөөг бий болгоно. Хүн өөрийн хязгаарлагдмал байдлыг ухамсарлаад үнэмлэхүй рүү тэмүүлдэг. Энэ бол хүний өвөрмөц ахуй юм. Хязгааргүй рүү тэмүүлж байгаагаараа хүн байгаагаасаа илүү дээд хүн болно. Тэр өөрөө өөрийнхөө нууц түлхүүр болно гэх мэтээр үзжээ.

Экзистенциализмын өөр нэгэн томоохон төлөөлөгч Камю зохиол бүтээлдээ: хүн бурханд итгэхээ болиод, хувийн амьдрал нь мөхлийн ирмэг дээр тулахад ямар байхыг дүрсэлдэг. Энэ үед амьдрал ямар ч утга учиргүй мэт санагдана. Бурханд итгэх итгэл нь хүний субъектив чанар, хувийн шинжийг үгүйсгэдэг. Бурханд шүтснээр хүн өөрийгөө чинад дээд оршихуйд аваачна. Хүн гав ганцаараа байж, туйлын төгсгөлдөө очиход амьдралынх нь утга учир алдагддаг хэмээсэн буй.

Камюгийн үзлээр хүн бүр янз бүрийн хувь зохиолоор үхэлтэй тулгарна. Үхэл бол бурхны шийтгэл. Хэрвээ бүгд үхэх л юм бол, бүгд бурхны шийтгэлээр орох л юм бол амьдралын утга учир гэж байна уу? Хүн үхэх юм бол амьдрах хэрэг байна уу? Цаг хугацаа чиний амьдралыг устгажээ. Хүн үхэхэд ухаан нь ч, мэдлэг нь ч, амьдрал нь ч, бүгд дуусна. Үхэл бол эрх чөлөө. Үймээн дэгдээгч нь туйлын тайван байдлыг хүсэхгүй, туйлын шудрага байдлыг хүсэхгүй, гэхдээ хүмүүсийг эвлэрүүлэхийг зорьж тэмцдэг боловч хүмүүсийг бутраадаг. Гэхдээ үймээн дэгдээх нь амьдралын төлөө тэмцэл мөн гэдэг.

Орчин буй ертөнцөө танин мэдэх гэсэн хүн төрөлхтний оюун санааны хөгжил гурван үе шатыг туулдаг гэж Конт үзсэн байна. Хүний оюун ухаан төрөлх чанараараа шашны, метафизикийн, позитив гэсэн сэтгэлгээний гурван аргыг туулах жамтай. Эндээс

эхэн, дунд, оргил гэсэн ертөнцийг үзэх гурван үзлийн систем үүсдэг хэмээн Камю үзжээ.

Түүний үзлээр оюун санааны хөгжил шашны үе дээрээ бүхий л үзэгдэл, үйл явцыг бурхан, сүнс, сахиусан тэнгэр, аврага баатар зэрэг далдын хүчний оролцоотойгоор тайлбарлаж, сэтгэлгээ чөлөөт бус, хаагдмал байдалд ордог. Хоёр дахь шатан дээрээ хүмүүст мэдрэгдэн хүртэгдэж байгаа үзэгдэл үйл явцын цаана нуугдах ертөнцийн анхдагч, чинад цаад мөн чанар, субстанцийг санаандаа эрэн сурвалжилна. Гэвч хүмүүс туршлагын хүрээнээс гарч чадахгүй учир субстанцийн тухай асуудал хэзээ ч хариугаа олохгүй. Энэ шатанд хүний сэтгэлгээ чөлөөлөгдөх боловч хоосон дүрслэл, мөрөөдлөөр хязгаарлагдана. Сүүлчийн позитив шатан дээр дүр төсөөллөөс илүү ажиглалт гол чухал болж тавигдана. Шинжлэх ухааны мэдлэг нь туршлага дээр үндэслэсэн эмпирик мэдлэг бөгөөд туршлагад хязгаар гэж байхгүй учраас мэдлэгт ч үнэмлэхүй туйл, төгсгөл гэж байхгүй. Шинжлэх ухаан гэдэг бол ямар нэг зорилгод хүрсэн төлөв биш, харин хязгаарлагдмал, дутуу мэдлэгээс илүү олон талтай, бүрэн мэдлэгт шилжих тасралтгүй үйл явц юм.

Позитивизмыг үндэслэгч хэмээн тооцогддог Контын үзлээр, социологи бол нийгмийн тухай эерэг (позитив) шинжлэх ухаан мөн. Өөрөөр хэлбэл нийгмийн тухай шинжлэх ухаан нь позитив арга зүйн гол зарчмыг мөрдөж, ажиглагдаж буй нийгмийн үзэгдлийн анхдагч шалтгаан, далд механизмыг эрэн сурвалжилалгүй, зөвхөн тэдгээрийг тайлбарлах үүрэгтэй байна.

Социологи нь сэтгэл хөдлөл, айх эмээх явдлыг гол үүрэгтэй гэж үздэг байна. Хүн орчин нөхцөлдөө дасахын зэрэгцээ түүнийг өөрчлөн хувиргах хандлагатай байдаг. Энэ нь практик үйл ажиллагаа болон оюуны бодрол гэсэн хоёр үйлдлээр илэрнэ. Орчиндоо дасан зохицох үйл ажиллагаа нь хүний сэтгэлгээг зогсонги байдалд оруулна. Эндээс соёл иргэншлийн хөгжлийн үе шатууд үүсвэрлэх ба үе шат бүхэнд үйл ажиллагааны арга нь тайлбарлах аргатайгаа зохицдог. Хамгийн эгэл болхи үе шат бол шашны үе юм. Хүн амьдрах нөхцөл хамгийн муу байхад шашин ноёрхдог. Ертөнцийг үзэх шашны үзэл ёсоор хүмүүнлэг ертөнц нь зөвхөн нөгөө ертөнцөд л байна гэж итгэн, энэ ертөнцийн хүнд бэрхийг даван туулахад нь шашин тусалдаг. Энэхүү хий үзэгдлийн нөлөөгөөр сэтгэл хөдлөн дсгдлох болсвч эрт орсй хэзээ нэгэн цагт хөшингө байдлаа орхидог. Оюун санааны амьдрал бол нийгмийн хөгжлийн хөдөлгөгч хүч юм. Гэр бүл бол нийгмийн үндсэн үүр юм. Гэр бүлд хүн төрөлхийн хувиа хичээх зангаа орхиж бусдын төлөө амьдарч сурдаг. Төр нь нийгмийн эв нэгдлийг ёс суртахуун, эдийн засаг, улс төрийн хувьд хангах үүрэгтэй байгууллага юм. Ёс суртахуун хийгээд улс төрийн үүргийг сүм хийд болон төрд хуваарилан ноогдуулах нь хамгийн зохистой бүтэц мөн. Сүм хийд нь иргэний ёс заншилд тулгуурлах ёстой хэмээн Конт үзжээ.

Оюун санаа нь шашны үе шатан дээрээ (1300 он хүртэл) фетишизм, политеизм, монотеизм гэсэн гурван дэд шатыг туулна. Метафизик үе дээрээ (1300-1800 он) уламжлалт шашин шүтлэг, нийгмийн хэв журмыг философийн шүүмжлэлээр (сэргэн мандалт, гэгээрэл, хувьсгалаар) бутаргана. Аж үйлдвэржсэн позитив шатан дээрээ (XIX зуунаас хойш) альтруист, нийгэмч үзэл, позитив философи дэлгэрнэ. Конт позитив философийг бүх нийтийн шашин болгохыг эрмэлзсэн ба энэ хэрэгт эрдэмтэд, жүжигчид чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзсэн юм.

Контын үзэл санааг залгамжилсан Спенсер орчлонгийн гарал үүслийн тухай гурван гипотез гаргасан байдаг. Үүнд: 1) орчлон өөрөө өөрөөрөө оршино, 2) өөрөө өөрийгөө бүтээсэн, 3) гадаад бүтээгчээр бүтээгдсэн. Байгаль өөрийгөө бүтээсэн, материас бүтсэн болон бурхан бүтээсэн, эсвэл ерөөс бүтээгдээгүй гэхийн аль аль нь бидний ухаанд ойлгогдох утга агуулгагүй зөвхөн үгэн тайлбар төдий юм.

Спенсерийн үзлээр шашны түүх болон шашин судлал нь ямар ч шашинд байдаг түгээмэл хувиршгүй элементийг тогтоож, орчлонгийн үндсэн дэх далд хүчийг туйлаас ухаарахгүйг хүлээн зөвшөөрүүлдэг. Шинжлэх ухаан ч мөн л орчлонгийн үндсэн мөн чанарыг танин мэдэж чадахгүй гэсэн дүгнэлтэд хүрдэг. Орон зай, цаг хугацаа, хөдөлгөөн, хуваагдмал чанар, матери, хүч, ухамсар, бие хүн зэрэг ойлголтууд нь бүгд зөрчилтэй учраас ухаарагдахгүй. Шашин, шинжлэх ухаан хоёрын ялгаа нь зөвхөн гадаад үзэгдлийн ялгаа юм. Шинжлэх ухаан нь өөрийнхөө тайлбаруудыг зөвхөн ойролцоо барагцаалсан, харьцангуй болохыг тогтоож, шашин нь өөрийн нууц далд хүчийг хэзээ ч тайлбарлагдашгүй, туйлын болохыг хүлээн зөвшөөрсөн цагт тэр хоёр адил болно. Танин мэдэгдээгүй юм танин мэдэгдэхгүй хэвээр л үлдэнэ гэж Спенсер үзсэн бөгөөд биологийн болон психологийн асуудлыг илүүтэй анхааран авч үзжээ.

Америкийн прагматик философийг үндэслэгч хэмээн тооцогддог Пирс шашин ба шинжлэх ухааныг эвлэрүүлэх оролдлого хийсэн юм. Тэрээр эргэлзээг эмпирик субъектын бодит эргэлзээ хэмээн сэтгэл зүйн үүднээс авч үзсэн юм. Хүн ямар нэг тодорхой зүйлд эмпирик юмуу сэтгэл зүйн үүднээс бодитой эргэлзэж болно. Үнэндээ сэтгэлийнхээ гүнд эргэлзэхгүй байгаа зүйлдээ эргэлзэж байгаа мэт дүр эсгэхээ больцгооё. Сэтгэлгээ нь сэтгэл зүйн үзэгдэл төлвүүдтэй холбоотой бөгөөд атгаг үзэл, сүсэг бишрэл, эргэлзээ тээнэгэлзлийн хүрээнд түгжигдмэл байдаг хэмээн тэрээр үзжээ.

Пирсийн үзлээр хүн ертөнцөд амьдарч үйл ажиллагаа явуулахын тулд тухайн нөхцөл байдалд зохицсон янз бүрийн дадал зуршилтай байх ёстой. Амьтны зөн совингоос урган гарсан энэхүү дадал зуршлууд нь ухамсарлагдсан тохиолдолд сүсэг бишрэл болдог. Сүсэг бишрэл гэдэг бол ямар нэг үйл ажиллагааг ямар нэг хэлбэрээр явуулах бэлэн байдал юм. Хэрвээ хоёр өөр үзэл санаа буюу хоёр өөр сүсэг бишрэлийн үүднээс нэг үйл ажиллагаа явуулж байвал тэдгээр нь хоёр өөр хэлээр илэрхийлэгдсэн нэг л сүсэг

бишрэл болно. Сэтгэл зүйн үүднээс үзэхэд сүсэг бишрэл нь ухаан санааны тайван, сэтгэл ханамжтай байдал юм. Хүний ухамсар бүхий л боломжит сүсэг бишрэлүүдээр дүүрэн байдаг. Гагцхүү янз бүрийн нөхцөл байдлын улмаас сүсэг бишрэл алдагдаж, эргэлзээ болж хувиран үйл ажиллагааг зогсоож болно. Эргэлзээ гэдэг бол тайван бус, сэтгэлийн таагүй байдал юм. Бид ийм байдлаас аль болох ангижрахыг хүсдэг. Эргэлзээг гэтэлж сүсэг бишрэлд хүрэх хүчин чармайлтыг судалгаа, сэтгэхүйн үйл ажиллагаа, логик бодомж гэнэ. Судалгаа буюу сэтгэлгээний цорын ганц зорилго нь эргэлзээг арилгаж сүсэг бишрэлд хүрэх явдал мөн хэмээжээ.

Пирс үзэхдээ: эргэлзээг арилгадаг үзэл санаа буюу сүсэг бишрэл нь үнэн мэдлэг гэсэнтэй ижил утга биш бөгөөд сүсэг бишрэлд ямар аргаар хүрэх нь хамаагүй юм. Ийнхүү үзэл санааны үнэн худал байх тухай болон сүсэг бишрэл буюу үзэл бодлын тухай асуудал ч чухал биш болж эргэлзээг гэтлэх чадвар, тэр нь сэтгэл зүйн тааламжит байдалд хүргэж чадаж буй эсэх тухай асуудал л гол болж байна. Судлаач хүн үнэн мэдлэг рүү биш, харин тогтвортой сүсэг бишрэл рүү тэмүүлдэг. Сүсэг бишрэлийн тогтвортой байдлыг хангах явдал нь үнэнд хүрэхээс чухал болно. Ийнхүү Пирс логик сэтгэлгээг сэтгэл зүйн талтай холбожээ.

Түүний үзлээр бидний сүсэг бишрэл тогтвортой байж, эргэлзээнд өртөхгүйн тулд тэр нь хүний дур зоргоос хамаарахгүйгээр, бидний сэтгэлгээ ямар ч нөлөө үзүүлж үл чадах тийм гадаад тогтвортой хүчин зүйлээс шалтгаалж байх ёстой. Чухам тэр хүчин зүйл нь л шинжлэх ухааны арга зүй болох учиртай юм. Байдлаар илэрдэг шинжлэх ухааны үндэслэлүүдийг аливаа сүсэг бишрэлийн нэгэн адилаар дадал зуршил буюу үйл ажиллагаа явуулах бэлэн байдал гэж үзвэл зохино гэдэг.

Үнэн нь сэтгэхүйтэй адил объектив бодит байдалтай хамаагүй, субъектын ухамсрын төлөв юм. Эргэлзээ ба сүсэг бишрэлээс ангид байдлаар үнэнийг ойлговол хэзээ ч ухаарагдахгүй мөн чанар, оршихуйн тухай ярих болно. Эргэлзээгүй сүсэг бишрэлд хүрэхийг хүсвэл үнэнд хүрэхийг хүссэнээс хамаагүй хялбар байх болно. Бидний сүсэглэж байгаа тэр зүйл л үнэн мөн. Тухайн өгүүлбэрт итгэхгүй, сүсэглэхгүй байх тохиолдолд тэр нь үнэн болж чадахгүй. Бидний сүсэг эргэлзээнд орж өөрчлөгдөх нь цөөнгүй. Чөлөөт сэтгэлгээ нь эргэлзээгүй найдвартай үнэнийг гарган авдаг. Гэвч шинжлэх ухаан ямагт алдаа гаргаж байдаг. Гагцхүү бид итгэж сүсэглэж байгаа тэр зүйл л үнэн байх болно гэх мэтээр сүсэг бишрэлийг авч үзжээ.

Америкийн сэтгэл судлаач-философич Жемс нь Пирсийн зарчмыг юуны өмнө сэтгэл зүйн болон шашин-ёс суртахууны асуудал дээр хэрэглэж, америкчуудын философийн сэтгэлгээнд төдийгүй шашны болон ердийн ухамсарт хүчтэй нөлөө үзүүлж, дундаж америкчуудын санаанд нийцсэн практик шинжтэй өвөрмөц философийг үүсгэжээ.

Жемсийн бичсэн "Сүсэг бишрэл нь хүсэл зоригоос хамаарах нь" зохиолын үзлээр бол, хүн төрөлхтөн шашингүйгээр оршин байж чадахгүй. Санамсаргүй, найдваргүй зүйлсээр дүүрэн энэхүү ертөнцөд хүн өөрийгөө аюулгүй гэж мэдрэхэд, амьдралын төлөө тэмцэлд нэмэлт хүч авахад шашин хэрэгтэй. Зовж зүдэрсэн хүмүүс ажил үүргээ хэвийн үргэлжлүүлэхэд нь бурханд итгэсэн сүсэг хэрэгтэй. Бурхан байгаа газар хэм хэмнэл, эмх цэгц ноёрхож, уйтгар гунигийг түр зуурын үзэгдэл хэмээн үл тоомсорлож чаддаг. Бурханд сүсэглэснээр амьдралаас тааламж хүртэж, хувийн амьдралаа зөв зохиох чадвартай болдог. Үүний тулд бурхныг заавал түгээмэл хязгааргүй, бүхнээс хүчтэй хэмээн батлах албагүй. Зөвхөн хэрэгтэй цагт нь хүний дэргэд байж, үүргээ биелүүлэхэд нь тусалж байхад л хангалттай. Бурхан бидэнд тусалж, бид түүний тусламжинд талархаж байвал болох нь тэр. Бурхан үнэнхээр бодьтой оршин байгаа юу, үгүй юу гэдэг асуудал чухал биш гэжээ.

Жемсийн үзлээр, шашин-сүсэг бишрэлийн мэдрэмж, хүртэхүй, туршлага нь хүмүүсийн амьдралд асар их үүрэг гүйцэтгэдэг. Бурханд итгэснээр хүний амьдралд чухал үр дагавар гардаг учраас бурхан бодьтой оршино гэж хэлж болно. Шашинд итгэдэг хүний ертөнц ба шашинд итгэдэггүй хүний ертөнц хоёр тэс өөр юм. Бидэнд харагдаж байгаа ертөнцөд бурхан байна гэсэн өчүүхэн ч шинж тэмдэг байхгүй. Хүрээлэн буй байгаль орчноосоо цааш гарахаар бид ертөнцийн шийдвэрлэгдэшгүй оньсоготой учирна. Бидний мэдэх ертөнцөөс өөр, шинжлэх ухаан, рационал сэтгэлгээнд өртөхгүй дээд ертөнц байгааг бид баталж чадахгүй. Ертөнц үнэндээ ямар гэдгийг бид мэдэж чадахгүй. Бүгдийг өөрсдийнхөө мэдэх тэрхүү өчүүхэн ертөнцийн хүрээнд л ойлгож тайлбарладаг. Бидний мэдэх цорын ганц туйлын ертөнц бол бие хүний ертөнц юм. Бие хүн, түүний сэтгэл хөдлөл, хүсэл сонирхол, зорилго чиглэл л жинхэнэ үнэн бодит байдал мөн бөгөөд тэр нь ертөнцөд юу болж байгааг тодорхойлж, түүнийг үнэлж цэгнэх туйлын эрх мэдэлтэй цорын ганц шалгуур юм.

Жемс үзэхдээ: Сүсэг нь рационал үндэслэгээгүй байсан тохиолдолд ч хүн сүсэглэсээр л байдаг бөгөөд өөрийн жирийн дур хүсэл, сэтгэл хөдлөлийн шаардлагаар л сүсэг бишрэлийн тусын тулд сонголт хийдэг юм. Бидний сэтгэл хөдлөл оршин байх эрхтэйгээс гадна хоёр саналын хооронд сонголт хийх эрхтэй билээ. Тэрхүү сонголт нь оюун сэтгэлгээгээр шийдвэрлэгдэхгүй ч үнэн байдаг. Хэн ч өөрийнх нь дур хүсэлд нөлөөлж байгаа сүсэг бишрэлээрээ аз турших эрхтэй. Дур хүсэл бол туйлын чөлөөтэй бөгөөд хоёрдмол байдлын аль нэгийг сонгох чадвартай байдаг. Бид өөрсдийнхөө эрх чөлөөг сэтгэлдээ хүлээн зөвшөөрч чадаж байвал тэр нь эрх чөлөөт байдал болно. Бурханд сүсэглэх нь тэрхүү чөлөөт дур хүсэлд үндэслэнэ. Миний сүсэглэж байгаа шашин худал мэт надад санагдвал би юу ч алдахгүй бөгөөд шашингүйн үзэлтнээс доор л лав орохгүй. Харин үнэн санагдвал өөрийгөө аварч байгаа учраас би хожих болно. Ямар нэг зүйлийг үнэн гэж итгэснээс тэр нь үнэн

болдог. Бурханд итгэсэн хүн итгээгүй хүнээс илүү амжилт гаргадаг. Бид итгэсэн учраас бурхан амьд, бодьтой болдог хэмээжээ.

Ийнхүү шашин, сүсэг бишрэлийн талаархи орчин үеийн философийн үзэл баримтлалууд нь сүсэг бишрэлийг нийгэм-түүхийн болон танин мэдэхүйн үүднээс авч үзэхээсээ илүү хувь хүний сэтгэлзүйн асуудалд холбогдуулан үзэж, шашин-сүсэг бишрэлийг бүхэлд нь сэтгэл судлалд оногдуулах чиг хандлага давамгайлж байна. Энэ нь хувь хүний амьдрал, үйл ажиллагаа, сэтгэл санааны ертөнцийг илүү дээдэлж, хүмүүнлэгийн үүднээс авч үзэж байгаатай холбоотой юм.

The basic philosophical ideas of the modern religious psychology

Religion and religious worship is a subject with very subtle branch and structure. However, the issue of religious psychology is mostly dependent on time, peculiar occasions of free space and subjective matters. For the research of religious psychology, there are some special methodologies such as behaviorism, gestalti psychology methods and psychoanalyses. In this article we are going to examine basic philosophical ideas of modern religious psychology such as irrationalism, positivism and pragmatism. They direct most attention on personal mental existence.

Ном зүй:

1. Ганхуяг Ш., Гантуяа М. Философийн түүхэн тойм. Гуравдугаар дэвтэр. УБ. 2002
2. Дагвадорж Д., Гантуяа М., Жамбал А. Шашин судлал. УБ.2001
3. Джеймс. Многообразие религиозного опыта. М.1993.
4. Зотов А.Ф. Западная философия XX века. М.1998
5. Ф.Ницше. По ту сторону добра и зла и др. Минск 1997. стр.451-452.
6. Фрейд З. Введение в психоанализ и др. Минск 1997.
7. Хрестоматия по истории философии (от Шопенгауэра до Дюркгейма) МГПУ. 1991
8. Юлина Н.С. Очерки философии в США. XX век. М.1999
Ясперс К. Философи ба шашин // Эрх чөлөө ба философи.. №6. УБ. 2000